



**“ШИНЭ ҮЕИЙН ЗАЛУУ СУДЛААЧ” СЭДЭВТ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

**2022 оны 05 сарын 11-ний өдрийн Лхагва гараг
МУИС-ийн Номын сангийн байрны 302 тоот хурлын танхимд**

09. ⁰⁰ -09. ⁵⁰	Бүртгэл		
10. ⁰⁰ -10. ¹⁵	Хурлын нээлт		
10. ¹⁵ -10. ⁴⁰	Уригдсан илтгэл		
10. ⁴⁰ -11. ¹⁰	Байгаль шинжлэлийн салбарын шилдэг илтгэл Хос системийн термодинамик дахь интеграл тэгшитгэл <i>Илтгэгч: Ц.Банзрагч, ШУС-БУС, Физик, докторант</i> <i>Удирдагч: ШУ-ны д-р Х.Цоохүү, Д-р Ц.Цогбаяр</i> Хаалттай бүхээг ашиглан нүүрсхүчлийн хийн урсгалыг тодорхойлох судалгаа (МУИС Өртөөний жишээн дээр) <i>Илтгэгч: Н.Нандинцэцэг, ХШУИС, Хүрээлэн буй орчин судлал, магистрант</i> <i>Удирдагч: Д-р Э.Мөнхцэцэг, Д-р А.Дашцэрэн</i>	Ханын илтгэлийн хэлэлцүүлэг: Бакалаврын шилдэг илтгэлүүд	
11. ¹⁰ -11. ⁴⁰	Инженерчлэлийн салбарын шилдэг илтгэл Бэлчээрийн ургамлын орчны стрессийг тэсвэрлэх чадварын судалгаа <i>Илтгэгч: Б.Батцэцэг, ХШУИС, Био-инженерчлэл, магистрант</i> <i>Удирдагч: Д-р, дэд проф. Б.Даваапүрэв, Д-р, проф. Ж.Батхүү</i> Бүтээгдэхүүний инноваци ба түүний санхүүгийн өгөөжид нөлөөлөх байдлыг уламжлалт болон хиймэл оюун ухааны аргуудыг ашиглан үнэлэх нь <i>Илтгэгч: М.Хулан, ХШУИС, Хэрэглээний математик, докторант</i> <i>Удирдагч: Д-р, проф. Д.Баянжаргал</i>		
11. ⁴⁰ -12. ¹⁰	Нийгмийн салбарын шилдэг илтгэл Монгол улсын төсвийн оновчлол ба цар тахлын нөлөө <i>Илтгэгч: Х.Анхбилэг, БС, Санхүү, магистрант</i> <i>Удирдагч: Д-р, дэд проф. Ч.Анхбаяр</i> Үйлчилгээний байгууллагын дотоод маркетингид нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа <i>Илтгэгч: Б.Сүндарь, Бизнесийн сургууль, Маркетинг, магистрант</i> <i>Удирдагч: Д-р Г.Урандэлгэр, Д-р Ч.Батбаатар</i>		
12. ¹⁰ -13. ⁰⁰	Цайны завсарлага		
12. ¹⁰ -13. ³⁰	Ханын илтгэлүүдэд санал өгөх		
13. ³⁰ -14. ⁰⁰	Хүмүүнлэгийн салбарын шилдэг илтгэл Аман болон бичгийн уран зохиол дахь тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмжийг задлан шинжлэх нь <i>Илтгэгч: И.Даваадорж, ШУС-ХУС, Утга зохиол судлал, магистрант</i> <i>Удирдагч: Д-р Д.Нямдорж</i> Хэлний зураглал дахь "ЦАГ" цогц ойлголт /монгол хэлний баримтаар/ <i>Илтгэгч: Э.Отгон-Эрдэнэ, ШУС-ХУС, Гадаад хэл шинжлэл, докторант</i> <i>Удирдагч: Д-р, проф. Н.Нансалмаа</i>		
14. ⁰⁰ -14. ³⁰	Илтгэлүүдтэй холбоотой санал, дүгнэлт, хэлэлцүүлэг		
14. ³⁰ -15. ⁰⁰	Шагнал гардуулах ёслол		
	Хаалтын үг		
	Зураг авахуулах ёслол		



БАКАЛАВРЫН ШИЛДЭГ ИЛТГЭЛҮҮД

№	Ханын илтгэл
1	XXI зууны төрийн албан хаагчийн цогц чадамж <i>Илтгэгч: Б.Зулцэцэг, ОУХНУС, Төрийн удирдлага, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр Г.Мягмар</i>
2	Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэд аргыг нэвтрүүлэх нь <i>Илтгэгч: Ө.Өсөхбаяр, ШУС-НУС, Улс төр, 3-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр О.Мөнхжаргал</i>
3	Аянга цахилгаантай аадар тунадасны аэросиноптик нөхцлийг WRF тоон загвараар судалсан дүн <i>Илтгэгч: Ц.Цолмон, Б.Нямцэцэг, ХШУИС, Цаг уур, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр Б.Ганболд</i>
4	Брежневийн Брежневийн БНМАУ-д хийсэн айлчлал, ХАА-н салбарт үзүүлсэн нөлөө <i>Илтгэгч: Б.Пүрэвдорж, ШУС-ХУС, БНУБ(Түүх), 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р, дэд проф. Б.Чинзориг</i>
5	Бүх төрлийн зориулалтын дронууд, тэдгээрийн олон улсын аюулгүй байдал, эрх зүйд нөлөөлж буй байдал <i>Илтгэгч: М.Хулан, ОУХНУС, Олон улсын харилцаа, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр Б.Баярцэнгэл</i>
6	Гүн сургалт ашиглан Монгол хэлний дохионы хэлийг хөрвүүлэх нь <i>Илтгэгч: Г.Саруул, ХШУИС, Компьютерийн ухаан, 2-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр З.Цолмон</i>
7	Гүний усан дахь ураны агуулгыг тооцоолох химийн хэмжил зүйн арга <i>Илтгэгч: Х.Луvsанбат, ШУС-БУС, Хими, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р, проф. О.Болормаа</i>
8	Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх зан үйлийг судалсан нь <i>Илтгэгч: Н.Сэндэнханд Б.Ачлалмаа, ШУС-НУС, Социологи, 2-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р, П.Цэрэнбазар</i>
9	Гэр хорооллын суурьшлын бүс дэх олон нийтийн төвийн төлөвлөлт (Чингэлтэй дүүргийн 16-р хорооны жишээн дээр) <i>Илтгэгч: Э.Тэмүүлэн, Г.Энх-Эрдэнэ, ШУС-БУС, Газарзүй, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р, дэд проф. Г.Гантулга</i>
10	Динамик Мальфаттын бодлого <i>Илтгэгч: Э.Өсөхбаяр, ХШУИС, Хэрэглээний математик, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р. Г.Баттөр</i>
11	Лийп моушн ашиглан робот гарын хөдөлгөөн удирдах нь <i>Илтгэгч: Г.Хүслэн, ХШУИС, Электроник, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р. Р.Амартүвшин, Д-р. Д.Сумъяаханд</i>
12	Метаноолоос диметил эфирийг гарган авах урвалын кинетик <i>Илтгэгч: М.Уранчимэг, ХШУИС, Химийн инженерчлэл, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р. Г.Тамираа, Д-р. А.Дэлгэржарал</i>
13	Монголын төрийн их Чойжин Агваанлуvsанхайдавын үйл ажиллагааг шинжлэх нь <i>Илтгэгч: Д.Ринчендорж, ШУС-ХУС, Шашин судлал, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р. С.Янжинсүрэн</i>
14	Мөнгө угаах, терроризмын талаарх мэдлэгийн түвшинг тодорхойлох нь <i>Илтгэгч: А.Отгонзаяа, Ү.Номин, Биз. сургууль, Нягтлан бодох бүртгэл, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр Э.Цэцэгдэлгэр</i>
15	Нөхөн төлбөрийн тархалтад үндэслэн авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийг тооцоолох нь <i>Илтгэгч: Э.Ижилцэцэг, Бизнесийн сургууль, Санхүү, 4-р түвшин</i> <i>Удирдагч: Д-р, дэд проф. Ч.Анхбаяр</i>
16	Ой тогтоолт ба дараалсан орчуулгын харилцан хамаарал <i>Илтгэгч: Б.Янжинлхам, Б.Сарангэрэл, ШУС-ХУС, Гадаад хэлний орчуулга, 3-р түвшин</i> <i>Удирдагч: Магистр Э.Ундраа</i>
17	Өдөр тутмын сонины улс төрийн мэдээллийн үзэл баримтлал уншигчдад нөлөөлөх нь <i>Илтгэгч: Б.Намуун, ШУС-НУС, Сэтгүүл зүй, 4-р түвшин</i>



- Удирдагч: ШУ-ны д-р, проф. М.Зулькафиль
- 18 **Өсвөр насны хүүхдүүдийн ганцаардалд нөлөөлдөг зарим хүчин зүйлийг судласан нь**
Илтгэгч: Н.Сэндэнханд, ШУС-НУС, Сэтгэл судлал, 3-р түвшин
Удирдагч: Магистр М.Тэгшбуян
- 19 **С.Буяннэмэхийн жүжгийн зохиолууд дахь баатрын орон зайн хэлбэрийн онцлог (“Марал шар”, “Шөнийн буг” жүжгийн жишээн дээр)**
Илтгэгч: С.Энхцэцэг, ШУС-ХУС, Утга зохиол, 4-р түвшин
Удирдагч: Д-р. Г.Нарантунгалаа
- 20 **Сонирхлын бүлэгт хамрагдах нь оюутнуудын манлайлалд нөлөөлөх нь**
Илтгэгч: Х.Оюунжунай, Биз. сургууль, Менежмент, 4-р түвшин
Удирдагч: Д-р. Г.Нарантунгалаа
- 21 **Таримал ойн өсөлтөнд сийрүүлэлтийн үзүүлэх нөлөө**
Илтгэгч: Г.Содбаяр, ХШУИС, Ойн аж ахуй, 4-р түвшин
Удирдагч: Д-р. С.Гэрэлбаатар
- 22 **Үнэлгээний пирамид ашиглан даалгаврын сан боловсруулах**
Илтгэгч: Д.Цэвээнсүрэн, ШУС-БУС, Багш, математикийн боловсрол, 4-р түвшин
Удирдагч: Д-р. дэд проф. А.Амарзаяа
- 23 **Хар Азаргын нурууны офиолит бүрдлийн онцлог, гарал үүслийн асуудал**
Илтгэгч: Э.Нямцэрэн, ШУС-БУС, Геологи, 4-р түвшин
Удирдагч: Д-р. дэд проф. Х.Уламбадрах
- 24 **Хаягдал ургамлын тос ашиглан биодизель гарган авах судалгаа**
Илтгэгч: Ө.Маралмаа, ХШУИС, Химийн инженерчлэл, 4-р түвшин
Удирдагч: Д-р. дэд проф. Ц.Төгсөө
- 25 **Хүний цусны ийлдсийн альбумин ба дапаглифлозин эмний харилцан үйлчлэл**
Илтгэгч: Т.Дүүрэнжаргал, ШУС-БУС, Химийн инженерчлэл, 4-р түвшин
Удирдагч: Д-р. Ө.Энэрэлт
- 26 **Цар тахлын үе дэхь сүм хийдийн үйл ажиллагаа**
Илтгэгч: Б.Наранхүү, Б.Дондов, ШУС-НУС, Антропологи, 4-р түвшин, 2-р түвшин
Удирдагч: Д-р. С.Бямбадорж
- 27 **Шугаман зардлын системд үндэслэн эрэлтийн загварыг шинжлэх нь: Монгол Улсын хүнсний гол нэрийн зарим бүтээгдэхүүн**
Илтгэгч: Д.Долгорсүрэн, ШУС-НУС, Эдийн засаг, 4-р түвшин,
Удирдагч: Д-р. Х.Цэвэлмаа
- 28 **Эдипийн комплексийн талаарх Ж.Лаканы тайлбарлалыг феминист философийн үүднээс авч үзэх нь**
Илтгэгч: Г.Инжирмаа, ШУС-ХУС, Философи, 4-р түвшин,
Удирдагч: Д-р. дэд проф. М.Отгонбаяр

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭЛИЙН САЛБАР**Сэдэв: Хос системийн термодинамик дахь интеграл тэгшитгэл***Илтгэгч: Ц.Банзрагч, ШУС-БУС, Физик, докторант**Удирдагч: ШУ-ны д-р Х.Цоохүү, Д-р Ц.Цогбаяр***Удиртгал:**

Орчин үед байгалийн ухааны салбарууд тэр дундаа физик, хими, биологи нь дан дангаараа хөгжихөөс илүүтэйгээр нэг уулзварт нийлж физик цогц систем, түүн дотор явагдах физик, хими, биологийн нийлмэл процессыг судлах болсон. Ийм судалгаа нь өнөө үед компьютер, тооцоолон бодох загварчлалтай хосолж улам хөгжсөөр байна. Энэхүү салбар хоорондын судалгааны чиглэлүүдийн нэг нь атом/молекулын хэмжээст ертөнцөд явагдаж буй физик, хими, биологийн процессын зүй тогтлыг судлах молекул динамикийн онолын судалгаа юм. Энэ онолын судалгаанд ашигладаг аргууд нь молекул динамикийн загварчлал, Монте-Карло (МК) болон интеграл тэгшитгэлийн (ИТ) (Орнстейн & Зерники, 1914) арга юм. ИТ арга нь физик системд агуулагдах бөөмсийн тооноос үл хамаардаг болохоор тооцоолон бодох хугацаа бага шаарддаг, улмаар системийн бүтцийг тодорхойлох корреляцын функцүүдийг шууд өгдгөөрөө дээрх аргуудаас давуу талтай. Энэхүү ажлын зорилго нь хос хатуу-бөмбөлөг болон Леннард-Жонс потенциалт системийн хувьд ИТ-ийн онолыг Перкус-Иевикын (Перкус & Иевик, 1968) ойролцоололд хэрэглэж, эдгээрийн даралт, илүүдэл химийн потенциал болон чөлөөт энергийг тооцоолж, бусад судлаачдын МК (Баросова, Малижевски, Лабик, & Смит, 1996, Хесиус & Сантос, 2018, Боровко & Загорски, 2000) үр дүнтэй харьцуулах явдал юм.

Сэдэв: Хаалттай бүхээг ашиглан нүүрсхүчлийн хийн урсгалыг тодорхойлох судалгаа (МУИС Өртөөний жишээн дээр)*Илтгэгч: Н.Нандинцэцэг, ХШУИС, Хүрээлэн буй орчин судлал, магистрант**Удирдагч: Д-р Э.Мөнхцэцэг, Д-р А.Дашцэрэн***Удиртгал:**

Байгаль дээрх нүүрстөрөгчийн хий (CO_2)-н урсгал нь газрын гадаргын экосистем болон агаар мандлын хооронд явагддаг. Энэхүү урсгал нь агаарт агуулагдах CO_2 -г фотосинтезийн процессоор ургамал шингээн авч, ургамал болон хөрсний амьсгалын процессоор агаар мандалд ялгаран CO_2 -н тэнцвэрт (Blanca) байдлыг бий болгодог (Nakano and Shinoda 2014). Сүүлийн жилүүдэд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар мандалд агуулагдах хүлэмжийн хийн (CO_2 , CH_4 мөн N_2O) агууламж нэмэгдэж, тэнцвэрт байдал ихээхэн алдагдсан нь дэлхийн дулаарлын гол шалтгаан болоод байна (Koskinen et al. 2014). Иймд уур амьсгалын өөрчлөлт, түүнийг сааруулахын тулд олон улсын томоохон гэрээ, конвенц, протоколд дэлхийн экосистем, бүс нутгийн хүлэмжийн хийг тооцоолох, түүнийг судлах шаардлагатай гэж үзсэн байдаг.

Хамгийн анх 1896 онд “Нүүрсхүчлийн давхар исэлд нөлөөлөх агаарын температурын тухай” судалгааг Arrhenius Svante хийсэн байдаг (Oertel et al. 2016). Энэ судалгаанд агаар мандалд орших CO_2 -н агууламжийн өөрчлөлт нь уур амьсгалын урт хугацааны өөрчлөлтөд нөлөөлсөн эсэх мөн чулуужсан түлшийг (нүүрс) шатаах нь дэлхий дулааралд хүргэж буй тухай анхны таамгуудыг дэвшүүлсэн байдаг (Arrhenius 1896). Энэ цагаас эхлэн олон улсын судлаачид хөрснөөс ялгарах хүлэмжийн хийн судалгааг газар бүрхэвчийн хувьд бэлчээр, ой, нүцгэн газар, тариалангийн талбай болон чийг намгархаг газраар, олон төрлийн арга зүй ашиглан судалсаар ирсэн (Oertel et al. 2016). Монгол орны хувьд АНУ-ын далай судлал, агаар мандлын үндэсний газар (NOAA)-ын харьяа хүлэмжийн хийн мониторингийн Улаан-уул өртөөг (Дорноговь аймгийн Эрдэнэ сум, UUM) 1992 онд байгуулагдсан бөгөөд одоог хүртэл CO_2 , CH_4 , CO , H_2 , N_2O ба SF_6 зэрэг хийн агууламжийн шинжилгээ хийж дүнг нь байнга хэвлэн нийтэлж байна (БОАЖЯ 2014). Харин хүлэмжийн хийн урсгал, түүний шинж чанарыг тодорхойлохтой холбоотой судалгааг 2008 оноос эхлэн бичил бүс нутгийн хэмжээнд, олон төрлийн арга зүй ашиглан хийсэн (Nakano, Nemoto, and Shinoda 2008; Miyazaki et al. 2014; Элбэгзаяа, Saito, and Батхишиг 2019; Nakano et al. 2020; Sharkhuu, n.d.; Халиунаа 2021) бөгөөд сүүлд зайнаас тандан судлалын аргазүй ашиглан “Монгол орны агаар дахь метан, нүүрсхүчлийн хийн агууламжийн оронзай, цаг хугацааны хуваарилалт, өөрчлөлтийг гаргасан байдаг (Adiya et al. 2021). Бид энэхүү судалгаагаар хаалттай бүхээг ашиглан МУИС, Цаг уур, ус судлалын сургалтын МУИС-Өртөө орчмын хөрсний CO_2 урсгалыг тодорхойлж, түүнд нөлөөлж буй цаг уурын үзүүлэлтүүдийн хамаарлыг судлах зорилго тавьсан. Энэ зорилгодоо хүрэхийн тулд:

- Судалгааны талбай орчмын цаг уурын үзүүлэлтүүдийн жилийн явцыг тодорхойлох;
- Хөрсний CO_2 -н мониторингийн урт хугацааны хэмжилтийг гүйцэтгэж, CO_2 -н урсгалыг шинж чанарыг тодорхойлох;
- CO_2 -н урсгал болон цаг уурын үзүүлэлт хэрхэн хамаарч буй хамаарлыг судлах зорилтуудыг тавилаа.

ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН САЛБАР

Сэдэв: Бэлчээрийн ургамлын орчны стрессийг тэсвэрлэх чадварын судалгаа

Илтгэгч: Б.Батцэцэг, ХШУИС, Био-инженерчлэл, магистрант

Удирдагч: Д-р, дэд проф. Б.Даваапүрэв, Д-р, проф. Ж.Батхүү

Удиртгал:

Монгол улсын газар нутаг нь өндөрлөг уулс, тал хээр, говь цөлийг хамарсан 1.566.600км² бөгөөд нийт нутгаар 3300 орчим зүйлийн ургамал ургадагаас 1,200 орчим зүйлийг нь 5 хошуу мал жилийн 4 улиралд ямар нэг хэмжээгээр иддэг. Монгол орон нь эрс тэс уур амьсгалтай ба дулааны улирлын оргил үед температур нь 40°C, хүйтний улирлын оргил үед -50°C хүрдэг. Мөн зуны сарууд нь богино, гандуу тул нутгийн ихэнх хэсгийн хөрс нь үржил шимт давхарга багатай, ургамлан бүрхэвч нь алаг цоог байдаг. Тиймээс ч манай оронд ургаж буй бэлчээрийн гэлтгүй бүх ургамал нь цаг уурын онцлог дасан зохицон хурдан соёолж богинохон зуны саруудад багтаан амьдралынхаа мөчлөгийг явуулж дуусгадаг онцлогтой. Энэхүү байгаль цаг уурын хүнд ширүүн нөхцөл нь ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг ба тэрхүү нөлөөг орчны стресс гэнэ. Энэхүү орчны стрессийг даван туулах физиологи, биохимийн процесс ургамалд түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтжээ

Тиймээс бид Монгол орны хатуу ширүүн байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлд дасан зохицож ирсэн хурдан соёолох чадвартай ургамлыг скринингийн аргаар илрүүлэн, хүрээлэн буй орчны стрессийг тэсвэрлэх чадварыг тогтоож, молекул биологийн механизмыг тайлбарлахыг зорив. Үүний тулд дараах зорилтыг тавив.

- Хурдан соёололттой бэлчээрийн ургамлыг илрүүлэх
- Хурдан соёололттой нь тогтоогдсон ургамлуудын соёололтын эрчим, соёолох идэвхийг нь тогтоох
- Хурдан соёололттой ургамлын тэжээллэг чанарыг тодорхойлох
- Хүрээлэн буй орчны стрессийг тэсвэрлэх чадварыг шалгаж, механизмыг илрүүлэх

Цаашлаад соёололтын хурд өндөртэй, орчны стресст тэсвэртэй нь тогтоогдсон ургамлаас түүнийг нөхцөлдүүлэгч генийг нь олж тогтоож чадвал тухайн ургамалд тухайн генийн нийлэгжлийг нэмэгдүүлэх замаар болцыг нь түргэтгэх, биомассыг нэмэгдүүлэх боломжтой болох юм.

Сэдэв: Бүтээгдэхүүний инноваци ба түүний санхүүгийн өгөөжид нөлөөлөх байдлыг уламжлалт болон хиймэл оюун ухааны аргуудыг ашиглан үнэлэх нь

Илтгэгч: М.Хулан, ХШУИС, Хэрэглээний математик, докторант

Удирдагч: Д-р, проф. Д.Баянжаргал

Удиртгал:

Инноваци бол шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, бизнес эрхлэх шинэ арга замыг тодорхойлж, бизнесийн ашиг, үндэсний орлого, хэрэглэгчдийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлдэг (Kim & Mauborgne 2005; Lee, Lee, & Garrett 2019; McDowell, Peake, Coder, & Harris 2018; Porter 1990; Schumpeter 1934; Teece, Pisano, & Shuen 1997). Пүүсийн инноваци болон ашиг орлогын хоорондын хамаарал ерөнхийдөө эерэг байдаг ч олон эмпирик судалгаагаар үр нөлөөний хэмжээ нь "практик ач холбогдолтой" гэж үзсэн түвшнээс доогуур байгааг харуулж байна. Энэ нь бүтээгдэхүүний болон пүүсийн орлогын түвшний хэмжүүрүүдийг хооронд нь холбодог инновацийн хэмжүүрүүдийн энгийн байдал, шууд бус өмнөх болон үр дагаварт хамаарах хэмжүүр, субъектив байдлаас ихээхэн шалтгаална. Энэхүү судалгаагаар бүтээгдэхүүний инноваци болон санхүүгийн өгөөжийн хэвийн бус өөрчлөлтийн шинжилгээний "нийлмэл" хэмжигдэхүүнийг ашиглан 2008-2008 онд Apple Inc-ээс Samsung болон бусад гар утас үйлдвэрлэгч компаниудтай харьцуулахад ухаалаг утасны зах зээлд нэвтрүүлсэн 174 шинэчлэл өөрчлөлт нь тухайн хугацаан дахь санхүүгийн хэвийн бус өгөөжид хэрхэн нөлөөлснийг үнэллээ. Судалгааны үр дүнд нөлөөллийн хэмжээ нь өмнө судлагдсан практик ач холбогдолтой түвшнээс илт давсан байгааг илрүүлсэн. Өөрөөр хэлбэл, iPhone-ийн шинэчлэл нь Apple-ийн хувьцааны санхүүгийн зах зээлийн үнэлгээний хэвийн бус өгөөжийн зөрүүний 65%-ийг тайлбарлаж байгааг судалгааны үр дүн тайлбарлаж байна. Энэхүү нийт өөрчлөлтийг зах зээлийн болон пүүсийн хувьд нэвтрүүлсэн шинэчлэл байдлаар хоёр салгаж авч үзвэл дараах үр дүнд хүрсэн. Зах зээлд цоо шинээр нэвтрүүлж буй инноваци санхүүгийн өгөөжийн хэвийн бус өөрчлөлтийн 83%-ийг урьдчилан таамаглаж байгаа бол тухайн пүүсийн хувьд шинээр гарч ирж буй шинэчлэл байдал нь үл ялиг нөлөөлдөг байна.

НИЙГМИЙН САЛБАР

Сэдэв: Монгол улсын төсвийн оновчлол ба цар тахлын нөлөө

Илтгэгч: Х.Анхбилэг, БС, Санхүү, магистрант

Удирдагч: Д-р, дэд проф. Ч.Анхбаяр

Удиртгал:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 2020-2021 оны Монгол улсын төсвийн орлогын болон зарлагын 88 улирлын тоон өгөдлийг ашиглаж Марковичийн багц сонголтын загвараар төсвийн орлого, зарлагын багцад үзүүлсэн цар тахлын өмнөх болон цар тахлын дараа үеийн гэсэн хоёр хэсэгт хувааж бүтцийн нөлөөг гаргасан, дараагийн хэсэгт квадрат програмчлал буюу оптимизациар оновчтой утгыг гаргаж, тухайн оновчтой утга анхны утгаас хэр зөрүүтэй байгааг нэг сигмагийн дүрмээр шинжилсэн болно.

Сэдэв: Үйлчилгээний байгууллагын дотоод маркетингид нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа

Илтгэгч: Б.Сүндарь, Бизнесийн сургууль, Маркетинг, магистрант

Удирдагч: Д-р Г.Урандэлгэр, Д-р Ч.Батбаатар

Удиртгал:

Энэхүү судалгааны ажлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй үүрэн телефоны операторууд болох Мобиком, Юнител, Скайтел, Жи-Мобайл компанийн үйлчилгээний ажилчидын сэтгэл ханамжинд байгууллагын дотоод маркетингийн нөлөөллийг тодорхойлон гаргасан. Ажилчдын сэтгэл ханамжинд дотоод маркетингийн хүчин зүйлс болох уурамшуулал (мөнгөн, мөнгөн бус), эрх мэдэл, сургалт хөгжил, удирдлага ажилчдын хоорондын харилцаа гэх мэт хүчин зүйлс нөлөөлдөг агаад дээрх үзүүлэлтүүд эдгээр үүрэн телефоны операторуудын үйлчилгээний ажилчдад хэрхэн нөлөөлж буйг энэхүү судалгааны үр дүнгээр тодорхойлон гаргасан. Судалгааг санамсаргүй түүврийн арга ашиглан авсан бөгөөд нийт 163 үр дүнтэй асуулга цуглуулж, SPSS болон Smart PLS 3.3 программуудыг ашиглан мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Судалгааны асуулгаар үйлчилгээний ажилчдын хүн ам зүйн үзүүлэлт болон аль үүрэн телефоны компанид ажилладаг, ажилласан жилийн туршлага нь тухайн хийж буй ажилдаа хэр сэтгэл ханамжтай байдаг, үүнд хэрхэн нөлөө үзүүлж буйг судалсан болно. Судалгааны үр дүнд ажилтанд чиглэсэн сургалт хөгжил, тухайн ажилтанд олгосон эрх мэдэл нь сэтгэл ханамжтай ажиллахад гол үүрэг гүйцэтгэсэн бол мөнгөн бус урамшуулал нь ажилтаны сэтгэл ханамжинд нөлөө үзүүлээгүй болно.

ХҮМҮҮНЛЭГИЙН САЛБАР

Сэдэв: Аман болон бичгийн уран зохиол дахь тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмжийг задлан шинжлэх нь

Илтгэгч: И.Даваадорж, ШУС-ХУС, Утга зохиол судлал, магистрант

Удирдагч: Д-р Д.Нямдорж

Удиртгал:

Тэнгэрийн зүүдний хүн, тэнгэрийн охины дүр, өгүүлэмж монгол домог болон шидэт үлгэрт түгээмэл тохиолдох нь бий. Ахар богино настай ч үзэсгэлэн гоо төгс бүсгүйн дүр олон орны аман болон бичгийн уран зохиолд дурдагддагийг судлаачид тэмдэглэжээ. Уг *тэнгэрийн зүүдний хүн* гэх ойлголтыг эрдэмтэн С.Дулам уран адилтгал-домог үг хэмээгээд, "...ер бусын гоо үзэсгэлэнтэй, зелдэг сайхан зан аальтай атлаа нас богинотой хүнийг "тэнгэрийн зүүдний хүн" байгаад тэнгэртээ буцаад харьчихсан юм юм байлгүй хэмээн хэлэлцдэг" (Дулам II, 2018) хэмээжээ.

Энэхүү илтгэлд дэлхийн дахинаа түгээмэл тархсан уг өгүүлэмж бүхий нэгэн домгийг бүтэцлэх аргаар задлан шинжилж, орчин үеийн уран зохиолд хэрхэн нөлөөлсөн, ямар харилцаа холбоонд буйг тодорхойлохыг зорилгоо.

Сэдэв: Хэлний зураглал дахь "ЦАГ" цогц ойлголт /монгол хэлний баримтаар/

Илтгэгч: Э.Отгон-Эрдэнэ, ШУС-ХУС, Гадаад хэл шинжлэл, докторант

Удирдагч: Д-р, проф. Н.Нансалмаа

Удиртгал:

Аль нэг хэлээр хэлэлцэгч ард түмний бодит ертөнцийг танин мэдэх үйлийн үр дүн болсон мэдлэгийн тогтолцоог хэлтэй холбон, хэлээр дамжуулан судалдаг танихуйн хэл шинжлэл хэл судлах орчин цагийн хандлага болоод байгаа билээ. "Цогц ойлголт" бол танихуйн хэл шинжлэлийн хэл судлах үндсэн нэгж юм. Хэл цогц ойлголтод нэвтрэх түлхүүр болно. Цогц ойлголтоор дамжуулан тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний танин мэдэх үйлийг тодорхойлж, хэлэнд шингэсэн агуулга, мэдлэгийг илрүүлэх боломжтой. Аль нэг цогц ойлголтыг нарийвчлан судалснаар тухайн ард түмний танин мэдэх үйл, амьдралын хэм хэмжээ, ёс заншил, ертөнцийг үзэх үзэл, байгаль цаг уурын нөхцөл байдал, нэг үгээр хэлбэл, амьдралд буй бүх зүйлийг хэлний баримтаар илрүүлэн тогтоож болно.

Монгол хэлийг танихуйн хэл шинжлэл талаас судлах, тэр дундаа цогц ойлголт судлах хандлага шинэ тутам, бие даасан судалгааны ажил эхлэл төдий байгаа нь энэхүү судалгааны ажлын ерөнхий үндэслэл болно гэж үзэв. "ЦАГ" цогц ойлголтыг жишээ болгон авч судалснаар цогц ойлголт судлах арга, аргачлалыг тодорхойлж, дараа дараагийн судалгааны ажлуудад эрдэм шинжилгээний ач холбогдолтой болохоос гадна, монголчууд уг цогц ойлголтыг хэрхэн хүлээж авдаг, ард түмний хамтын ухамсарт энэхүү цогц ойлголт хэрхэн бий болсон, ямар бүтэцтэйг хэлний баримтаар тодорхойлж "бид хэн бэ? бид яагаад ийм бэ?" гэх асуултад нэг цогц ойлголтын хүрээнд хариу өгч чадах юм.

БАКАЛАВРЫН ШИЛДЭГ ИЛТГЭЛҮҮД

1. Сэдэв: XXI зууны төрийн албан хаагчийн цогц чадамж

Илтгэгч: Б.Зулцэцэг, ОУХНУС, Төрийн удирдлага, 4-р түвшин

Удирдагч: Магистр Г.Мягмар

Удиртгал:

МУ-ын 21-р зууны төрийн албан хаагчдад шаардагдах мэдлэг, чадвар, хандлага ба үнэт зүйлсийг дэлхийн ирээдүйн чиг хандлагатай уялдуулан тодорхойлон, тэдгээр цогц чадамжийг олгож буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, зөвлөмж боловсруулах

- Төрийн албаны ирээдүйн нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
- Ирээдүйн төрийн албан хаагчдад шаардагдах цогц чадамжийг олгож буй эсэхийг судлах
- Цогц чадамжийн талаарх онолын ойлголт судлах
- Ирээдүйн төрийн албан хаагчийн цогц чадамжийн загварыг боловсруулах

2. Сэдэв: Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэд аргыг нэвтрүүлэх нь

Илтгэгч: Ө.Өсөхбаяр, ШУС-НУС, Улс төр, 3-р түвшин

Удирдагч: Магистр О.Мөнхжаргал

Удиртгал:

Бидний амьдарч буй нийгэмд төрийн үйлчилгээг авахад олон төрлийн хүндрэл бэрхшээл үүсдэг. Жишээ нь: Төрийн албаны хүнд суртал, олон төрлийн бичиг баримт бүрдүүлэлт, олон сая төгрөгийн авилгал нэхэх, бүтэн долоо хоногийнхоо ажлаас татгалзах, нэг даргын хүссэн нөгөө даргын гарын үсэг цуглуулах гэх мэт явдлууд нийтлэг тохиолддог байна. Хэрвээ та монгол төрийн үйлчилгээ авч байсан л бол эдгээр асуудлуудаас аль нэг нь танд тулгарсан гэдэгт эргэлзэхгүй байна. Иймд энэхүү судалгааны ажлын хүрээнд авилгачаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох үйл ажиллагаанд хэрэглэж буй сайн туршлагаудыг судлах болно. Нэгэн жишээ дурдахад Австри улсын Вена хотод нийт иргэдийн 75 хувь нь өдөр тутамдаа төрийн бүхий л үйлчилгээг авахдаа “цахим технологи” ашигладаг байна. Иймд аль ч нийгмийн хувьд том асуудал болсон авилгал хэмээх асуудлыг дэвшилтэт аргаар багасгаж чадсан улс орнуудын туршлагыг задлан шинжлэх судлах нь улс төрийн салбарын судалгаанд ач холбогдол өндөртэй юм.

3. Сэдэв: Аянга цахилгаантай аадар тунадасны аэросиноптик нөхцлийг WRF тоон загвараар судалсан дүн

Илтгэгч: Ц.Цолмон, Б.Нямцэцэг, ХШУИС, Цаг уур, 4-р түвшин

Удирдагч: Магистр Б.Ганболд

Удиртгал:

Судалгаанд GLD360 аянга цахилгаан бүртгэгч багажийн бүртгэсэн 2019 оны 07 сарын 03 өдөр төвийн бүс нутгаар ажиглагдсан аянга цахилгаан, аадар борооны тохиолдлыг сонгон авч WRF загвараар 4 мужаар (27км, 9км, 3км, 1км) бодуулж дотоод мужийн хүрээнд үүлний микрофизик үзүүлэлтүүд дээр дүн шинжилгээ хийв. Мөн тухайн үеийн цаг агаарын газар өндрийн анализ зураг ашиглан аэросиноптик нөхцөлийн задлан шинжилгээг хийв. Дулаан фронт дайран өнгөрөхөд албадмал конвекц үүсэж борооны бөөн үүл үүссэн байна. Энэ үүлнээс GLD360 багажид 364 минут үргэлжилсэн аянга цахилгаан ажиглагдав. Мөн загварын мэдээг бодит ажиглалтын мэдээтэй тулгаж, бодит байдалд хэр зэрэг ойртож байгааг нийлбэр хур тунадасны хэмжээгээр харьцуулан харуулав.

4. Сэдэв: Брежневийн БНМАУ-д хийсэн айлчлал, ХАА-н салбарт үзүүлсэн нөлөө

Илтгэгч: Б.Пүрэвдорж, ШУС-ХУС, БНУБ(Түүх), 4-р түвшин

Удирдагч: Д-р, дэд проф. Б.Чинзориг

Удиртгал:

Илтгэлийн хүрээнд Л.И.Брежневийн айлчлалын БНМАУ-ын ХАА-н салбар дахь үзүүлсэн нөлөө, үр дагаврыг судлахыг зорилгоо. Үүний тулд Монгол Зөвлөлтийн гадаад худалдааны харилцааны нөхцөл байдлыг тодруулж, Л.И.Брежневийн хэрэгжүүлж байсан бодлого үйл ажиллагааны онцлогийг тодорхойлох болно. Л.И.Брежнев нь БНМАУ-д айлчилсан цорын ганц төрийн тэргүүн байсан ба түүний айлчлал Монголын ХАА-н салбарт, ялангуяа хөдөө аж ахуйн тулгуур болсон нэгдэлд ямар үр дүн, нөлөө үзүүлснийг архивын баримтад тулгуурлан тодруулах гэж оролдсонд илтгэлийн шинэлэг тал оршино.

5. Сэдэв: Бүх төрлийн зориулалтын дронууд, тэдгээрийн олон улсын аюулгүй байдал, эрх зүйд нөлөөлж буй байдал

Илтгэгч: М.Хулан, ОУХНУС, Олон улсын харилцаа, 4-р түвшин

Удирдагч: Магистр Б.Баярцэнгэл

Удиртгал:

Энэхүү судалгааны ажил нь олон улсын аюулгүй байдалд нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийн хэрэглээ өсөн нэмэгдэх болсон төдийгүй улс орнуудад ч үүний эсрэг өөрсдийн аюулгүй байдлаа хамгаалах зайлшгүй хэрэгцээтэй тулгарч байгаа бөгөөд энэхүү технологийн дэвшил нь хөгжлийнхөө эрчийг аваад байгаа энэ цаг үед энэ технологийн цаашдын хөгжлийн төлөв төдийгүй боломжит аюулаас хамгаалах арга замын талаар судлахад судалгааны зорилго оршино.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд байлдааны ажиллагаа явуулахдаа нисгэгчгүй агаарын тээврийг ашиглах нь нэмэгдэж байгаа нь энгийн иргэдийн аюулгүй байдалд ноцтой аюул учруулаад зогсохгүй улс хооронд дрон ашиглан цэргийн ажиллагаа явуулах явцдаа үл ойлголцох байдал үүсгэж байна. Нисгэгчгүй агаарын тээврийн техникийн хувьд олон талт байдал нь тодорхой ангилалд шууд оруулахад төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж байгаа бөгөөд олон улсын эрхзүйгээр зохицуулахад бэрхшээлтэй байгаа юм. Жижиг хэмжээ, өндөр нарийвчлал нь улс болон улс бус тоглогчдын анхаарлыг ихэд татаж, амархан зэвсэглэх, далд хэлбэрээр ашиглах боломжийг нэмэгдүүлснээр зэвсгийн ил тод байдал болон хариуцлагын зарчмыг зөрчиж байна.

6. Сэдэв: Гүн сургалт ашиглан Монгол хэлний дохионы хэлийг хөрвүүлэх нь

Илтгэгч: Г.Саруул, ХШУИС, Компьютерийн ухаан, 2-р түвшин

Удирдагч: Магистр З.Цолмон

Удиртгал:

Бид энэхүү ажлаар Монгол дохионы хэлний анхны орчуулагчийг хүний онцлог цэгүүдийн гүн сургалтын аргаар бий болгов. Компьютер дүрс боловсруулалтын салбарт энэ төрлийн асуудал дээр гүн сургалтын арга хэрэглэж сургахад их хэмжээний өгөгдөл шаардлагатай байдаг. Одоогоор дэлхийд 300 гаруй дохионы хэл байдаг бөгөөд улс бүр өөрсдийн дохионы хэл байдаг бөгөөд улс бүр өөрсдийн дохионы хэлтэй байдаг. Бид энэ ажлын хүрээнд Монгол хэлний анхны дохионы хэлний өгөгдлийг үүсгэж ашигласан болно. Бидний эхний ээлжид 10 өгүүлбэрийг илэрхийлсэн дохионы хэлний өндөр чанартай видеог бэлтгэн үүнээс хүний нүүр, цээж, баруун, зүүн гараас нийтдээ 1662 ширхэн хүний биеийн онцлог цэгүүдийг ашиглан сургасан гүн сургалтын загвар гаргаж авав. Бидний сургасан загвар 96% нарийвчлалтайгаар дохионы хэлний зөв таньж орчуулдаг болсон.

7. Сэдэв: Гүний усан дахь ураны агуулгыг тооцоолох химийн хэмжил зүйн арга

Илтгэгч: Х.Лувсанбат, ШУС-БУС, Хими, 4-р түвшин

Удирдагч: Д-р, проф. О.Болормаа

Удиртгал:

Ундны усан дахь уран нь хүний биед хөдөлгөөний саатал, нойргүйдэл, фиброз, элэг үхжих, бөөрний үйл ажиллагаа алдагдах зэрэг сөрөг нөлөө үзүүлдэг. Тиймээс ундны буюу гүний усан дахь ураны агуулгыг тогтмол судалж, хянаж, тодорхойлж байх чухал шаардлагатай юм. Гэсэн хэдий ч гүний усан дахь ураны агуулга нь харьцангуй бага тул тодорхойлохын тулд орчин үеийн, нарийвчлал өндөртэй спектроскопын аргуудыг ашигладаг. Спектроскопын аргууд нь цаг хугацаа, дээж бэлтгэл, ур чадвар, хөрөнгө хүч ихээр шаарддаг тул улс орон бүр тогтмол ашиглах боломжгүй байдаг. Энэхүү судалгааны ажлаар гүний усан дахь ураны агуулгыг гидрохимийн параметруудад үндэслэн тооцоолох **хялбар, хурдан, хямд** аргыг боловсруулах зорилго тавьсан.

8. Сэдэв: Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх зан үйлийг судалсан нь

Илтгэгч: Н.Сэндэнханд Б.Ачлалмаа, ШУС-НУС, Социологи, 2-р түвшин

Удирдагч: Д-р, П.Цэрэнбазар

Удиртгал:

Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлж, тусламж үзүүлбэл дахин гэмт хэрэг үйлдэгдэх, мөн хүүхэдтэй зүй бус харьцах зэрэг хүчирхийллийн нэмэлт хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой (Sulak, Saxon, & Fearon, 2014). Гэвч гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсонтой холбоотой нийгмийн буруушаалт нь мэдээлэх эсвэл тусламж хайхад саад учруулж болзошгүй (Dobash & Dobash, 1992). Мөн гэр бүлийн хүчирхийлэл нь хувийн асуудал гэсэн хандлага нь 34% нь гэмт хэргийн талаар мэдээлэхээс сэргийлдэг болохыг тогтоожээ (Felson & Pate, 2005). Иймийн тулд гэр бүлийн хүчирхийллийн талаар хүмүүсийн мэдээлэх зан үйлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах, энэхүү зан үйлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах шаардлага тулгарч байна.

9. Сэдэв: Гэр хорооллын суурьшлын бүс дэх олон нийтийн төвийн төлөвлөлт (Чингэлтэй дүүргийн 16-р хорооны жишээн дээр)

Илтгэгч: Э.Тэмүүлэн, Г.Энх-Эрдэнэ, ШУС-БУС, Газарзүй, 4-р түвшин

Удирдагч: Д-р, дэд проф. Г.Гантулга

Удиртгал:

Олон нийтийн төв буюу “community center” гэх ойлголт нь Улаанбаатар хотын дийлэнх иргэдийн хувьд төрийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээ эсвэл худалдаа, үйлчилгээний газраар ойлгогддог. Угтаа энэ нь боловсрол, нийгэм, соёл, эрүүл мэндийн үйл ажиллагааны тусламжтайгаар янз бүрийн бүлэгт хамаарах иргэдийн хоорондын харилцаа холбоог бий болгох зорилготой нийтийн орон зай юм (Rick Van Urk). Олон нийтийн төвийг орон зай, хүн амын төвлөрөл, төр, нийгэм, бизнесийн үйлчилгээний хүртээмжийг харгалзан үзэж шатлалтайгаар зохион байгуулна. Харин бичил олон нийтийн төвийг 1926 онд Кларенс А.Пэрригийн боловсруулсан Хот төлөвлөлтийн үндсэн нэгж болох хөршлөлтийн тухай онолоор төлөвлөж болно.

10. Сэдэв: Динамик Мальфаттын бодлого

Илтгэгч: Э.Өсөхбаяр, ХШУИС, Хэрэглээний математик, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Г.Баттөр

Удиртгал:

1803 онд Италийн математикч Мальфатт “Өгөгдсөн гурвалжинд гурван тойргийг талбайнуудын нийлбэр нь хамгийн их байхаар, огтлолцуулахгүйгээр хэрхэн байрлуулах вэ?” гэсэн бодлогыг анх тавьсан. Мальфаттын бодлогыг бодохоор 200-аад жилийн хугацаанд маш олон судлаачид олон янзын арга онолыг боловсруулсаар ирсэн байдаг. Уг оновчлолын бодлого нь гүдгэр функцийг гүдгэр биш олонлог дээр максимумчлах бодлого учраас ерөнхий тохиолдолд NP-hard- төрлийн бодлого юм.

Одоо бид Мальфаттын бодлогыг өргөтгөн 3-н хэмжээст бодит огторгуйд ($n=3$ үед) тодорхойлж болно.

Ингэснээр Мальфаттын бодлого нь:

Өгөгдсөн зөв гурвалжин пирамидад дөрвөн бөмбөлгийг өгөгдсөн муруйнууд дээр төв нь оршиж, эзлэхүүнүүдийн нийлбэр хамгийн их байхаар огтлолцуулахгүйгээр хэрхэн байрлуулах вэ? Гэсэн бодлого тавигдана. Энэ бодлогыг бид **динамик Мальфаттын бодлого** гэнэ.

Нөгөө талаас Мальфаттын бодлого нь Тойргуудын агуулалтын (Circle packing) бодлогын тухайн тохиолдол бөгөөд орчин үед дараах салбаруудад өргөнөөр ашиглагдаж байна. Үүнд:

- Объектын оновчтой байршлыг тогтоох бодлогууд
- Ачаа бараа, контейнейрыг тээвэрлэх тээвэр логистикын бодлогууд
- Аж ахуйн нэгж, компаниудын ашигтай ажиллах цар хүрээг тодорхойлох, эрсдэлийн хэмжээг тодорхойлох бодлогууд
- Уул уурхайн салбарт флотацын процессыг загварчлахад тус тус ашиглаж байна.

11. Сэдэв: Лийп моушн ашиглан робот гарын хөдөлгөөн удирдах нь

Илтгэгч: Г.Хүслэн, ХШУИС, Электроник, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Р.Амартүвшин, Д-р. Д.Сумъяаханд

Удиртгал:

Робот гар нь хүний хөдөлмөрийг хөнгөвчилж, ажлын бүтээмжийг дээшлүүлдэг учир олон салбарт ашиглагдах болсон ч түүнийг удирдахад ихээхэн хүндрэлтэй байдаг. Энэхүү судалгааны ажлаар энэ асуудлыг шийдэхэд туслах робот гарын удирдлагын системийг хөгжүүлж, түүний математик загварыг боловсруулж, робот гарыг хүний гар шиг хөдөлгөөн, хялбар удирдах зорилготой юм. Ингэхдээ лийп моушн мэдрэгч ашиглан түүний боловсруулсан цэгүүдээр зургаан чөлөөний зэрэг бүхий робот гарыг хүний гарын хөдөлгөөнийг даган хөдөлгөх удирдлагын программ хангамжийг пайтон хэл дээр хөгжүүлж, робот гарын барих хэсгийн координатыг олдог болсон бөгөөд үр дүнд нь робот гарыг хүссэн байрлалд аваачихад үе тус бүр хэрхэн хөдлөхийг тооцоолж чаддаг болсон. Үе тус бүрийг хөдөлгөх боломжтой болсноор робот гарыг шатар нүүх гэх мэт олон сонирхолтой хэрэглээнд ашиглах боломжтой болж байгаагаараа давуу талтай.

12. Сэдэв: Метанолоос диметил эфирийг гарган авах урвалын кинетик

Илтгэгч: М.Уранчимэг, ХШУИС, Химийн инженерчлэл, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Г.Тамираа, Д-р. А.Дэлгэржарал

Удиртгал:

Дэлхийн улс оронд эрчим хүч нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хамгийн том шаардлагын нэг бөгөөд хүн төрөлхтний хамгийн том асуудал юм. Энергийн эх үүсвэрүүдээс цахилгаан болон түлшний эх үүсвэрийг хангах бөгөөд Монгол улсад баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэр нь үндсэн технологийн 12 байгууламжаас бүрдэнэ. Нүүрс, байгалийн хий, биологийн хог хаягдлыг эрчим хүчний хэрэглээнд ашиглан DME үйлдвэрлэлснээр хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулж түлшний хүртээмжийг сайжруулах боломжтой юм. Энэхүү ажлаар метанолоос диметилийн эфирийг гарган авах усгүйжүүлэх урвалын кинетикийг загварчлахыг зорьсон. Үүнд Химийн урвал, реактор, катализатор, гетероген урвалыг судлаад DWSIM дээр кинетикийг загварыг загварчлах мөн онол, туршилтийн утгыг харьцууллаа.

13. Сэдэв: Монгол төрийн их Чойжин Агваанлуvsанхайдавын үйл ажиллагааг шинжлэх нь

Илтгэгч: Д.Ринчендорж, ШУС-ХУС, Шашин судлал, 4-р түвшин

Удирдагч: Д-р. С.Янжинсүрэн

Удиртгал:

Лувсанхайдавын намтар үйл ажиллагааг судлан, холбогдох архивын болон бусад баримтыг шинжлэх нь Чойжингийн талаарх судалгааг өргөжүүлэх, Богд хаант Монгол улсын үеийн түүхийг баяжуулах, монголын шашин судлалын мистик, эзотерик асуудлыг судалгааны сан томтой болгох, монголын буддын шашны хөгжил, зан үйлийн онцлог шинж байдлыг тодруулах чухал ач холбогдолтой болно гэж үзэж байна.

14. Сэдэв: Мөнгө угаах, терроризмын талаарх мэдлэгийн түвшинг тодорхойлох нь

Илтгэгч: А.Отгонзаяа, Ү.Номин, Биз. сургууль, Нягтлан бодох бүртгэл, 4-р түвшин

Удирдагч: Магистр Э.Цэцэгдэлгэр

Удиртгал:

Манай улсын аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчид болон тус мэргэжлээр суралцаж буй оюутнуудын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх үйл ажиллагааны талаарх ойлголт, мэдлэг, мэдээллийн түвшинг тодорхойлж, урьдчилан сэргийлэх шатан дах хяналтыг сайжруулах боломжийг судлахыг зорьсон. Мөн Финланд болон Исланд улсуудын мөнгө угаах, терроризмтой тэмцэх зарим үйл ажиллагааг харьцуулан үзэж манай улсын практикт нэвтрүүлэх боломжтой эсэхийг судлан, санал дэвшүүлсэн.

15. Сэдэв: Нөхөн төлбөрийн тархалтад үндэмлэн авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн хувийг тооцоолох нь

Илтгэгч: Э.Ижилцэцэг, Бизнесийн сургууль, Санхүү, 4-р түвшин

Удирдагч: Д-р, дэд проф. Ч.Анхбаяр

Удиртгал:

Энэхүү судалгаанд авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн хувийг тархалтын загварчлалд тулгуурлан тодорхойлно. Үүний тулд бид даатгалын компанийн нөхөн төлбөрийн өгөгдлийг авч үзэн статистик тархалтын аргаар хураамжийн хувийг тооцоолсон.

16. Сэдэв: Ой тогтоолт ба дараалсан орчуулгын харилцан хамаарал

Илтгэгч: Б.Янжинлхам, Б.Сарангэрэл, ШУС-ХУС, Гадаад хэлний орчуулга, 3-р түвшин

Удирдагч: Магистр Э.Ундраа

Удиртгал:

In general, interpreting is based on the balance of many variables and conflicting abilities. Thus, our paper will present a theoretical overview of the concept of working memory and how it may contribute to the quality of (consecutive) interpreting. Working memory, therefore, might be an essential resource in the interpreting process. Our goal is to show the impact on the quality of CI regarding the fact that memory is one of the vital parts of interpreting.

17. Сэдэв: Өдөр тутмын сонины улс төрийн мэдээллийн үзэл баримтлал уншигчдад нөлөөлөх нь

Илтгэгч: Б.Намуун, ШУС-НУС, Сэтгүүл зүй, 4-р түвшин

Удирдагч: ШУ-ны д-р, проф. М.Зулькафиль

Удиртгал:

Судалгааны үндэслэл ач холбогдол: Ямар сэтгүүл зүй байна тийм л нийгэм байна. Сонгуульд идэвхтэй оролцдог насны бүлгийнхэн өдөр тутмын сонин унших нь элбэг, Улс төрийн нам эвсэл аль нэг үзэл суртлыг сурталчилж, өөрийн намын үйл ажиллагааг дэмжиж байж болзошгүй, өдөр тутмын сонинууд энэ тал дээр анхаарах, бичлэгийн бүтэц, арга барилаа өөрчлөх, уншигчид мэдээллээ шүүн тунгааж, эргэцүүлэн унших, эх сурвалжийн үүрэг гүйцэтгэх.

18. Сэдэв: Өсвөр насны хүүхдүүдийн ганцаардалд нөлөөлдөг зарим хүчин зүйлийг судласан нь

Илтгэгч: Н.Сэндэнханд, ШУС-НУС, Сэтгэл судлал, 3-р түвшин

Удирдагч: Магистр М.Тээшбуян

Удиртгал:

Ганцаардал бол орчин нийгэмд хүний сэтгэл зүйд тулгамдаж буй асуудал юм. Судалгаагаар 20 хүртэлх насныхны амиа хорлолтын гол шалтгаан нь ганцаардалт болох нь харагджээ (Сарантуяа ба Хишигням, 2014). Мөн эмпирик өгөгдлүүдээс харахад өсвөр насныхан ахмадуудаас илүү ганцаардлыг мэдэрдэг. Өсвөр насныхан биологийн, нийгмийн хөгжлийн янз бүрийн шилжилтийг мэдэрч байдаг. Энэхүү шилжилтүүдээс болж өсвөр насныхны хувьд ганцаардлын илрэл нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж, харъяалагдах хүсэл эрмэлзлээр илэрдэг. Ганцаардсан өсвөр насныхан сэтгэлийн хямрал, сэтгэлийн түгшүүр нийгмийн амьдралаас хөндийрч, амиа хорлох санаа бодол, оролдлогууд, психосоматик гомдол (толгой өвдөх, дотор муухайрах гэх мэт) ба ерөнхий эрүүл мэндийн байдал муу зэрэг шинж тэмдэг илэрдэг аж (Bridget J. Goosby, Anna Bellatorre, Katrina M Walsemann, Jacob E, Cheadle, 2013). Тийм учраас өсвөр насны хүүхдүүдийн ганцаардалд онцгой анхаарал хандуулж, үүсгэгч хүчин зүйлийг судлах нь чухал юм.

19. Сэдэв: С.Буяннэмэхийн жүжгийн зохиолууд дахь баатрын орон зайн хэлбэрийн онцлог (“Марал шар”, “Шөнийн буг” жүжгийн жишээн дээр)

Илтгэгч: С.Энхцэцэг, ШУС-ХУС, Утга зохиол, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Г.Нарантунгалаа

Удиртгал:

Уран зохиолын бүтээлд дүр, баатар /personage/ нь өөрийн өгүүлэхүйн хэлбэр, сэтгэлзүйн орон зай, үйл явдал өрнөх орчин болон сэтгэлгээний орчин зэрэг гадаад дотоод орон зайн бүх хэмжүүрийн нарийн тогтолцоонд оршдог. Бид нэг талаас уран зохиолын орон зайн тухай шинэ ойлголтыг /spatial form/, нөгөөтэйгүүр С.Буяннэмэхийн урлан, арга барилын нэгээхэн бүрдэл хэсэг болох баатрын орон зайн хэлбэрийг бүтээсэн туурвилзүйн өнцгийг шинэ талаас ажиглах юм.

20. Сэдэв: Сонирхлын бүлэгт хамрагдах нь оюутнуудын манлайлалд нөлөөлөх нь

Илтгэгч: Х.Оюунжунай, Биз. сургууль, Менежмент, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Г.Нарантунгалаа

Удиртгал:

Бусдад нөлөөлөх чадвар, хүн бүрд байгууллага, бүлгийн өмнө тавигдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүсэл, тэмүүлэл төрүүлэх урлаг буюу манлайлал нь өнөөгийн хурдацтай хөгжиж, улам бүр даяарчлагдаж буй ертөнцөд асар их ач холбогдолтой байгаа сэдэв билээ. Тийм ч учраас олон дээд боловсролын байгууллага оюутны манлайлах чадварыг хөгжүүлэхээр зорин ажилладаг ба манлайллын хөгжил нь өөрөө олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Гэвч юун түрүүнд эргэн тойронд хүрээлэх хүмүүс, бүлэг байснаар тэр дунд манлайлал боломж бий болдог. Иймд өөрийн хүсэл сонирхол, зорилгынхоо хүрээнд аливаа сонирхлын бүлэгт элсэх нь оюутны манлайлалд нөлөөлдөг эсэхийг аргазүйн үндэслэлтэйгээр харуулах үүднээс энэхүү сэдвийг сонгож авсан болно.

21. Сэдэв: Таримал ойн өсөлтөнд сийрүүлэлтийн үзүүлэх нөлөө (Тужийн нарс таримал нарсан ойн жишээн дээр)

Илтгэгч: Г. Содбаяр, ХШУИС, Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим

Удирдагч: Д-р. С. Гэрэлбаатар

Удиртгал:

Иймд таримал ойн, ойн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг байнга өсч байна. Ойжуулалтын ажлын үр дүнд бий болсон таримал ойг цаашид өндөр бүтээмж бүхий ой болгохын тулд түүнд Ойн аж ахуйн арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай. Таримал ойг тодорхой схемийн дагуу тарьдаг ба ургамал хоорондын зай, өрсөлдөөн, өсөлтийн явцын онцлогоос хамааруулан сийрүүлэх огтлолтыг хийдэг. Энэхүү судалгааны ажлын зорилго нь таримал ойн өсөлтөнд харилцан адилгүй эрчимтэй огтлолтын дараах таримал ойн өсөлт, титмийн хөгжлийг харьцуулан судлах, таримал нарсан ойд явуулах сийрүүлэх огтлолтын тохиромжтой эрчмийг харьцуулсан судалгааны үндсэн дээр тогтооход оршино.

22. Сэдэв: Үнэлгээний пирамид ашиглан даалгаврын сан боловсруулах

Илтгэгч: Д. Цэвээнсүрэн, ШУС-БУС, Математикийн тэнхим-багш, математикийн боловсрол

Удирдагч: Д-р. А. Амарзаяа

Удиртгал:

Нидерландын “Үнэлгээний пирамид” нь “Сэтгэлгээний түвшин”, “Математикийн агуулгууд”, “Бодлогын хүндрэл” гэсэн гурван хэмжээснээс бүрддэг. Сэтгэлгээний “Давтах”, “Холбох”, “Шинжлэн дүгнэх” түвшин бүр дээр математикийн янз бүрийн агуулгын хүрээнд даалгавар боловсруулах боломжтой. Үнэлгээний пирамид ашиглан даалгаврын сан боловсруулснаар багш тухайн хичээлийн сэдвээ томоор харж, сурагчдад цэгцтэй мэдлэг олгохын зэрэгцээ сурагчдын сэтгэн бодох үйлийг төлөвшүүлж чадна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд зөвхөн ЕБС-ийн 10 дугаар ангийн “Функц ба график” сэдвийг авч үзсэн боловч “Үнэлгээний пирамид” ашиглан бүхий л сэдэв дээр даалгаврын сан боловсруулах боломжтой юм.

23. Сэдэв: Хар азаргын нурууны офиолит бүрдлийн онцлог, гарал үүслийн асуудал

Илтгэгч: Э. Нямцэрэн, ШУС-БУС, Геологи-геофизикийн тэнхим, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Х. Уламбадрах

Удиртгал:

Төв азийн Ороген бүс (ТАОБ) мөн Алтайд гэж нэрлэгддэг бүс нь дэлхий дээрх хамгийн том аккрецийн орогены нэг ба Уралаас Номхон далай хүртэл (баруунаас зүүн тийш), Сибирь, Дорнод Европын (Балтик) кратоноос Хойд Хятад, Таримын кратон хүртэл (хойноос урагшаа) сунан байрласан байдаг. ТАОБ-ийн хэмжээнд офиолит бүрдлүүд ихээхэн хадгалагдаж үлдсэн байдаг, түүнд Монгол орны эзлэх байр суурь томоохон ач холбогдолтой юм. Монгол орны Нуурын бүс нь гол төлөв хожуу Неопротерозой- түрүү Кембрийн вулканоген-тунамал чулуулгаас тогтсон бөгөөд үүнд олон тооны офиолит ба Далайн плитийн стратиграфи (ДПС)-ийн хэсгүүд багтдаг. Нуурын бүсийн гол офиолит бүрдлүүд бүсийн зүүн захыг эмжин, хойноос өмнө тийш тархан байрлахаас гадна нас нь төсөөтэй тогтоогдсон ба мөн түүний төв хэсгээр ч хадгалагдан үлдсэн нь бий. Эдгээрээс анхаарал татахуйц том хэмжээтэй боловч өнөөг хүртэл судлагдаагүй үлдсэн Хар Азаргын нурууны офиолит бүрдэл дээр бид анхаарал хандуулж байна. Хар Азаргын офиолит нь Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагт Хар Азаргын нуруунд тогтоогдсон. Энэхүү офиолит нь найрлага, структурын хувьд Хантайшир, Даривын офиолиттой маш төстэй боловч төдийлөн сайн судлагдаагүй байна. Хар Азаргын офиолит нь 4 км өргөнтэй, 50 км хүртэл үргэлжилдэг. Офиолит нь ойролцоогоор 150 км² талбайг эзэлдэг ба Эдиакари-түрүү Кембрийн серпентинитжсэн хэт суурилаг чулуулгаас Хантайшир формацын гүн усны цахиурлаг, шаварлаг хурдас, алевролит хүртэлх ДПС-ийн чулуулаг бүхий офиолитын бүрэн зүсэлтийг агуулдаг (Togtokh et al., 1995).

24. Сэдэв: Ашигласан ургамлын тосыг дахин эфиржүүлэн биодизель түлш гарган авах судалгаа

Илтгэгч: Ө. Маралмаа, ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Ц. Төгсөө

Удиртгал:

Энэхүү судалгааны хүрээнд хаягдал, ашигласан ургамлын тосны химийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрээс хоёр шаттай дахин эфиржүүлэлтээр биодизель гарган авав. Тосны дээжүүдийг дахин эфиржүүлэх урвалын тохиромжтой нөхцөлийг хэд хэдэн багц туршилтуудын үр дүнд тогтоосон. Үүнд: Тос:Метанол:Катализаторын молийн харьцаа 1:6:1/40, урвалын температур 60°C, хугацааг 30 минут, хутгалт 650 эрг/мин, метанол нь тохиромжтой урвалж болохыг тогтоосон. Ургамлын ашигласан тосноос гарган авсан биодизелийг зуны дизель түлштэй эзлэхүүний 10%, 15%, 20%-иар хольж бэлтгэсэн бүтээгдэхүүн нь дизелийн түлшний техникийн шаардлагыг хангасан.

25. Сэдэв: Хүний цусны ийлдсийн альбумин ба дапаглифлозин эмийн харилцан үйлчлэл

Илтгэгч: Т. Дүүрэнжаргал, ШУС-БУС, Биологийн тэнхим, Биофизик, 4-р түвшин

Удирдагч: Д-р. О. Энэрэлт, Д-р. М. Цогбадрах

Удиртгал:

Хүний цусны ийлдсийн альбумин (ХЦИА) нь бүтцийн хувьд маш сайн судлагдсан уураг бөгөөд эндоген болон экзоген нэгдлийг бай эрхтэнд хүргэх үүрэгтэй зөөвөрлөгч уураг юм. Дапаглифлозин нь 2-р хэлбэрийн чихрийн шижин өвчинд хэрэглэх ба натри-глюкоз хам зөөвөрлөгч -2 (НГХЗ-2)-ийг хориглодог. Альбумин уургийн өвөрмөц шинж чанарт үндэслэн дапа эмтэй харилцан үйлчлэх механизмыг судлах нь шинэ эмийн дизайныг боловсруулах фармакологийн ач холбогдолтой. Бид харилцан үйлчлэлийн механизмыг физиологийн орчинд (рН 7.4) флуоресценци спектроскопи, синхрон флуоресценци, 3D флуоресценци, UV-Vis шингээлт болон зета-потенциалийн арга зүйг ашиглаж судлав. Штерн-Волмерийн тэгшитгэлээр холболтын тогтмол (K_A) мөн холболтын сайтын тоог (n) гурван өөр температурт (298K, 303K, 308K) тооцоолоход $0.523 \times 10^{-1} M^{-1}$, $0.303 \times 10^{-1} M^{-1}$, $0.264 \times 10^{-1} M^{-1}$, мөн холболтын сайтын тоо гурван температурт ($n \approx 1$) байлаа. Термодинамик параметрийг Вант-Гоффийн тэгшитгэлийн ашиглаж энтальпи (ΔH) энтропи (ΔS) болон гиббсийн (ΔG) чөлөөт энергийг термодинамик онолд ($\Delta H > 0$, $\Delta S > 0$, $\Delta G < 0$) тулгуурлаж тодорхойлов. ХЦИА уураг ДАПА эмтэй харилцан үйлчлэхэд гарч буй уургийн хоёрдогч болон

гуравдагч бүтцийн өөрчлөлтийг UV-Vis спектрофотометр, 3D флуоресценцийн үр дүнгээр баталгаажуулав. Түүнчлэн ХЦИА нь ДАПА эмтэй холбогдоход ХЦИА уургийн гадаргуугийн цэнэгийн өөрчлөлтийг рН 7.4 орчинд тодорхойлоход -22.38мВ байсан бол ДАПА эмтэй харилцан үйлчлэхэд -34.51мВ болсон нь гидрофоб харилцан үйлчлэлд орж буйг батлав.

26. Сэдэв: Цар тахлын үе дэхь сүм хийдийн үйл ажиллагаа

Илтгэгч: Б. Наранхүү, Б. Дондов, ШУС-НУС, Антропологи, Археологийн тэнхим

Удирдагч: С. Бямбадорж

Удиртгал:

Цар тахлын нөлөөлөл дэлхий дахинд хүчтэйгээр нөлөөлж, нийт хүн төрөлхтний амьдралын хэвшил эргэлт буцалтгүйгээр өөрчлөгдөн, салбар бүрд харилцан адилгүй нөлөөллийг үзүүлсээр байна. Тэдгээрийн нэгт нийгмийн амьдралын томоохон хүрээ болох шашны институт зүй ёсоор багтах ба цар тахлын улмаас хамгийн ихээр хэлмэгдсэн салбаруудын нэг хэмээн хэлэхэд төдийлөн буруудахгүй. Одоогоор үүний үр дагавар, хувь хүнд хийгээд нийгмийн оюун санаанд үзүүлэх нөлөөлөл нь ихээхэн сонирхууштай асуудал байгаа бөгөөд судлагдах шаардлагатай сэдвүүдийн нэг болоод байна. Уг судалгаа нь 2021.10.03 – 2022.04.15-ны өдрүүдэд судалгааны гол объект болох сүм, хийд, төрийн бус байгууллага зэрэг шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагаанд уялдуулан нийт 6 сарын хугацаанд гүйцэтгэсэн. Энэхүү ажлын явцад тухайн байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, дотоод бүтцийг нь таньж мэдэх, сүсэгтнүүд ба номлогч, лам санваартнуудын нийгэм, сэтгэл зүйн онцлогийг таньж мэдэх, Буддын болоод Христийн сүмүүд дэх цар тахлын үеийн нөхцөл байдалд харьцуулалт хийн дүгнэлт гаргахыг зорьсон.

27. Сэдэв: Шугаман зардлын системд үндэслэн эрэлтийн загварыг шинжлэх нь: Монгол улсын хүнсний гол нэрийн зарим бүтээгдэхүүн

Илтгэгч: Д. Долгорсүрэн, Биз. сургууль, эдийн засаг тэнхим, 4-р түвшин

Удирдагч: Д-р. Х. Цэвэлмаа

Удиртгал:

LES загварын тэгшитгэлийг Монгол Улсын нэг өрхийн жилийн дундаж мөнгөн орлого, зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дундаж хэрэглээ болон тэдгээрийн дундаж үнийг 2007-2020 оны “ӨНЭЗС”-г ашиглан өрхийн шийдвэр гаргалт буюу эрэлтэд эдгээр хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгааг ХБКА-р үнэлэн ач холбогдлыг шалгах. Сонгон авсан бүтээгдэхүүнүүдийн өөрийн үнийн мэдрэмж, солбисон үнийн мэдрэмж, орлогын мэдрэмжийг тодорхойлж хүчин зүйлсийн нөлөөллийг тайлбарлах.

28. Сэдэв: Эдипийн комплексын талаарх Ж. Лаканы тайлбарлалыг феминист философийн үүднээс авч үзэх нь

Илтгэгч: Г. Инжирмаа, ШУС-ХУС, Философи, 4-р түвшин

Удирдагч: М. Отгонбаяр

Удиртгал:

Эмэгтэйчүүд болон хүүхдүүд өөрсдийн амьдарсаар ирсэн, одоо ч амьдардаг тэр нийгмээсээ хүнийссэн, идэвхтэй субъектив чанар бүхий бусдын дур таталтыг фантазладаг амьтад болж таарч байна. Тэдний энэ “дайвар” /маргинал/, нөгөө хүйсээс хараат байдал нь түүхэн урт хугацааны туршид үргэлжилсэн учир эргээд хүний амьдралын илүү гүнзгий, экзистенциал, индивидуал психологи, үл ухамсарлахуйн түвшинд нэвт шингэжээ. Лаканыхаар Фрейдin дэвшүүлсэн Эдипийн комплекс бүрэн утгаараа амьдралд хэрэгждэггүй ч хүний үл ухамсарлахуйтай холбогдоно. Хүний өөрийгөө таньж мэдэх шат хүүхэд байх үеэс эхэлдэг бөгөөд биологийн онцлогоос шалтгаалан нийгэмд иррээрхи тогтолцоо байх ёсгүйг түүний дэвшүүлсэн онолоор дамжуулан харуулахыг зорилго. Мөн ухамсар, хэл дэх эмэгтэй ба эрэгтэй гэх үзэгдлийг тайлбарлах боломжийг психоаналитик феминизм бидэнд олгодог ач холбогдолтой.